



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөст сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/10/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар  
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn  
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн  
Утас: 70432545  
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn  
Аудитор: Ц.Бадрал  
Утас: 91983443  
Цахим хаяг: badralts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

**МӨСТ СУМЫН ТӨСВИЙН  
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ  
С.БААСАНДОРЖ ТАНАА**

2023.03.25 № 02/МН  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ХЯЗГААРЛАЛТАЙ ДҮГНЭЛТ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мөст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, төсвийн хөрөнгийн зарцуулалт сул, ойн хандивын зарцуулалтын анхан шатны баримтыг бүрдүүлэлт бүрэн бус, түлээ нүүрс, шатахуун, эмийн зарцуулалтад тавих дотоод хяналтгүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зэрэгтэй холбоотой 568.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Мөст сумын татварын орлогын гүйцэтгэл 618.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Татварын орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 23.1 сая төгрөг, үйл ажиллагааны орлого 5.0 сая төгрөг, хөрөнгө борлуулсны орлого 3.1 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн татвар 0.8 сая төгрөг, бууны албан татвар 0.8 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 49.2 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1.2 сая төгрөг, газрын төлбөр 0.5 сая төгрөг, торгуулийн орлого 1.9 сая төгрөгөөр тус тус орлого давж, хөрөнгийн орлого 10.9 сая сая төгрөг, шууд бус орлого 17.5 сая төгрөг, малд ногдуулах татвар 5.4 сая төгрөг, ан амьтан нөөц ашигласны төлбөр 92.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

021020426

Мөст сумын түүхт 80 жилийн ойн арга хэмжээ болж 100.3 сая төгрөгийн хандив цугларч ойн арга хэмжээг тэмдэглэсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Өмнөх онуудад төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг байсан Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн санхүүгийн тайлангийн тогтмол зардлаас бусад үзүүлэлтүүд системийн дээд байгууллагын тайланд нэгтгэгдэх бодлогын өөрчлөлт бий болсонтой холбоотойгоор эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд нөлөөлөл бүхий өөрчлөлтүүд орсон байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Сумын ИТХ-ын 8/03 тогтоолоор Сумын засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хангалттай гэж үнэлсэн байна.

Сумын ЗДТГ нь 5 зорилтын хүрээнд 6 арга хэмжээ, 92 заалтын биелэлтийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилт 92 хувьтай үнэлэгдсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код:   | Тайлангийн үзүүлэлт                         | Мянган.төгрөгөөр      |                        |
|--------|---|-----------------------|------------------------|
|        |   | 2021оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
| 1      | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН                     | 990,758.30            | 647,441.80             |
| 31     | МӨНГӨН ХӨРӨНГӨ                              | 233,006.40            | 179,510.90             |
| 33     | АВЛАГА                                      | 251,621.20            | 245,118.00             |
| 34     | УРЬДЧИЛГАА                                  | 177,509.50            | 182,509.50             |
| 35     | БАРАА МАТЕРИАЛ                              | 328,621.20            | 40,303.40              |
| 2      | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН                 | 5,890,004.70          | 1,390,493.60           |
| 39     | ҮНДСЭН ХӨРӨНГӨ                              | 5,890,004.70          | 1,390,493.60           |
| 39200  | Биет хөрөнгө                                | 5,721,837.30          | 1,277,195.20           |
| 39300  | Биет бус хөрөнгө                            | 168,167.40            | 113,298.40             |
| 3      | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II                 | 6,880,763.00          | 2,037,935.40           |
| 4      | НИЙТ ӨР ТӨЛБӨР                              | 86,048.30             | 14,790.30              |
| 41     | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР                   | 86,048.30             | 14,790.30              |
| 41300  | Өглөг                                       | 86,048.30             | 14,790.30              |
| 5      | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН                    | 6,794,714.80          | 2,023,145.00           |
| 51     | Засгийн газрын хувь оролцоо                 | 6,794,714.80          | 2,023,145.00           |
| 51100  | Засгийн газрын оруулсан капитал             | 3,305,184.70          | 695,532.90             |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө       | 3,305,184.70          | 695,532.90             |
| 51200  | Хуримтлагдсан үр дүн                        | 890,228.30            | 672,497.60             |
| 51300  | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү            | 2,422,464.40          | 655,114.50             |
| 6      | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 6,880,763.00          | 2,037,935.40           |

### 2.2 Аудит санхүүгийн үр дүнгийн тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт             | Мянган.төгрөгөөр      |                        |
|------|---------------------------------|-----------------------|------------------------|
|      |                                 | 2021оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
| I    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 3,995,388.90          | 1,287,708.10           |
| 11   | ТАТВАРЫН ОРЛОГО                 | 298,170.70            | 618,748.30             |
| 110  | Орлогын албан татвар            | 50,305.20             | 214,794.10             |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 50,305.20             | 214,794.10             |
| 113  | Хөрөнгийн албан татвар          | 2,285.50              | 50,640.10              |
| 118  | Бусад татвар, төлбөр, хураамж   | 245,580.00            | 353,314.10             |
| 12   | ТАТВАРЫН БУС ОРЛОГО             | 458,387.80            | 182,904.50             |
| 120  | Нийтлэг татварын бус орлого     | 458,387.80            | 182,904.50             |
| 13   | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО   | 3,238,830.30          | 486,055.30             |
| II   | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН     | 3,741,746.00          | 1,255,742.40           |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ                   | 3,741,746.00          | 1,255,742.40           |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,958,505.60          | 1,220,856.60           |

|      |  |              |               |
|------|--|--------------|---------------|
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 1,810,326.90 | 394,567.40    |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 232,726.20   | 48,959.40     |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 82,890.20    | 114,794.60    |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         | 277,866.90   | 230,526.10    |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 7,597.10     | 5,078.60      |
| 2107 | Томилолт, зочны зардал                                   | 4,412.10     | 3,282.10      |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 12,937.90    | 117,360.70    |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 399,721.80   | 306,287.60    |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 783,240.50   | 34,885.80     |
| III  | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)                    | 253,642.80   | 31,965.80     |
| V    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН                          | 0            | 4,835,735.90  |
| VI   | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)          | 253,642.80   | -4,803,770.10 |

### 2.3 Аудит санхүүгийн үр дүнгийн тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт                             | Мянган.төгрөгөөр                       |                        |
|------|---|--|------------------------|
|      |   | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
| 1    | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 5,882,419.80                           | 5,882,419.80           |
| 2    | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | 66,866.50                              | 66,866.50              |
| 3    | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 5,949,286.20                           | 5,949,286.20           |
| 4    | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 414,948.40                             | 414,948.40             |
| 5    | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт                  | 176,837.30                             | 176,837.30             |
| 9    | Тайлант үеийн үр дүн                            | 253,642.80                             | 253,642.80             |
| 10   | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 6,794,714.80                           | 6,794,714.80           |
| 11   | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл             | 6,794,714.80                           | 6,794,714.80           |
| 12   | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | 32,200.40                              | 32,200.40              |
| 13   | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 6,826,915.10                           | 6,826,915.10           |
| 19   | Тайлант үеийн үр дүн                            | -4,803,770.10                          | -4,803,770.10          |
| 20   | 2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл           | 2,023,145.00                           | 2,023,145.00           |

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт                    | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|------|--|------------------------|------------------------|
| I    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 3,604,435.50           | 1,145,960.50           |
| 11   | ТАТВАРЫН ОРЛОГО                        | 298,170.70             | 618,748.30             |

|      |  |              |             |
|------|--|--------------|-------------|
| 110  | Орлогын албан татвар                                     | 50,305.20    | 214,794.10  |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар                          | 50,305.20    | 214,794.10  |
| 113  | Хөрөнгийн албан татвар                                   | 2,285.50     | 50,640.10   |
| 118  | Бусад татвар, төлбөр, хураамж                            | 245,580.00   | 353,314.10  |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж                            | 17,294.30    | 54,460.60   |
| 1181 | Газрын төлбөр  | 225.9        | 2,197.80    |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр                          | 228,059.80   | 296,655.70  |
| 12   | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                      | 74,324.20    | 31,156.90   |
| 120  | Нийтлэг татварын бус орлого                              | 74,324.20    | 31,156.90   |
| 13   | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                            | 3,231,940.60 | 496,055.30  |
| II   | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                        | 3,256,660.00 | 954,910.30  |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ  | 3,256,660.00 | 954,910.30  |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 2,454,502.20 | 918,056.90  |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 1,809,431.20 | 394,597.10  |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 240,622.00   | 48,585.00   |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 96,907.00    | 115,634.70  |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         | 67,731.20    | 17,934.70   |
| 2105 | Нормативт зардал   | 129,232.40   | 333         |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 10,987.50    | 12,614.30   |
| 2107 | Томилолт, зочны зардал                                   | 4,412.10     | 3,282.10    |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 16,155.20    | 120,003.60  |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 79,023.60    | 205,072.40  |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 802,157.80   | 36,853.30   |
| III  | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)      | 347,775.40   | 191,050.30  |
| V    | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)                | 208,625.40   | 195,545.80  |
| 22   | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ   | 208,625.40   | 195,545.80  |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр                                      | 208,625.40   | 195,545.80  |
| VI   | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)    | -208,625.40  | -195,545.80 |
| VII  | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН   | -20,212.60   | -49,000.00  |
| 23   | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ               | 20,212.60    | 49,000.00   |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)        | 118,937.40   | -53,495.50  |
| 101  | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | 114,069.00   | 233,006.40  |
| 20   | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        | 233,006.40   | 179,510.90  |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Мянган төгрөгөөр

| Код | Үзүүлэлт                          | Төлөвлөгөө  | гүйцэтгэл   |
|-----|-----------------------------------|-------------|-------------|
| II  | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,194,214.4 | 1,043,158.8 |
| 21  | УРСГАЛ ЗАРДАЛ                     | 856,420.8   | 803,613.1   |

|        |   |                    |                    |
|--------|---|--------------------|--------------------|
| 210    | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                          | <b>792,846.8</b>   | <b>767,405.4</b>   |
| 2101   | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                               | 412,142.2          | 394,597.1          |
| 2102   | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл                  | 51,328.1           | 48,585.0           |
| 2103   | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                       | 118,799.9          | 115,634.7          |
| 2104   | Хангамж, бараа материалын зардал                                | 18,161.8           | 17,934.7           |
| 2105   | Нормативт зардал  | 335.3              | 333.0              |
| 2106   | Эд хогшил, урсгал засварын зардал                               | 5,812.5            | 5,789.9            |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл                                    | 167.0              | 167.0              |
| 210604 | Урсгал засвар   | 5,645.5            | 5,622.9            |
| 2107   | Томилолт, зочны зардал  | 3,601.6            | 3,282.1            |
| 2108   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b> | <b>120,071.6</b>   | <b>119,154.0</b>   |
| 2109   | Бараа үйлчилгээний бусад зардал                                 | 62,593.8           | 62,094.8           |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                                 | 62,593.8           | 62,094.8           |
| 213    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | <b>63,574.0</b>    | <b>36,207.7</b>    |
| 2132   | Бусад урсгал шилжүүлэг  | 63,574.0           | 36,207.7           |
| 22     | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>   | <b>287,793.6</b>   | <b>190,545.8</b>   |
| 23     | <b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>               | <b>50,000.0</b>    | <b>49,000.0</b>    |
| III    | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                           | <b>1,194,214.4</b> | <b>1,100,767.7</b> |
| 32     | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                           | <b>1,133,540.6</b> | <b>1,074,575.8</b> |
| 35     | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>                    | <b>60,673.8</b>    | <b>26,191.9</b>    |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                       | 605.0              | 1,129.0            |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                       | 0.0                | 25,062.9           |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих                                   | 60,068.8           | 0.0                |
| 4      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                |                    | 63,556.4           |
| 5      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл               |                    | 120,519.7          |
| 6      | <b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>                         | <b>138</b>         | <b>138</b>         |
| 61     | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>   | <b>6</b>           | <b>6</b>           |
| 62     | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>   | <b>66</b>          | <b>66</b>          |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код    | Үзүүлэлт  | ТЗ цэвэр дүн / төгрөгөөр / |
|--------|---|----------------------------|
| II     | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>  | <b>161,531,578.00</b>      |
| 21     | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>156,531,578.00</b>      |
| 210    | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>  | <b>150,651,578.00</b>      |
| 2106   | Эд хогшил, урсгал засварын зардал   | 6,824,407.00               |
| 210604 | Урсгал засвар   | 6,824,407.00               |
| 2108   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>                                   | <b>849,600.00</b>          |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                              | 849,600.00                 |
| 2109   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>  | <b>142,977,571.00</b>      |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал   | 142,977,571.00             |
| 213    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | <b>5,880,000.00</b>        |
| 2133   | <b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>  | <b>5,880,000.00</b>        |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 5,880,000.00               |
| 22     | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>   | <b>5,000,000.00</b>        |
| 2200   | <b>Дотоод эх үүсвэрээр</b>  | <b>5,000,000.00</b>        |

|             |   |                       |
|-------------|---|-----------------------|
| 225106      | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал  | 5,000,000.00          |
| <b>I</b>    | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>   | <b>161,531,578.00</b> |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | <b>161,531,578.00</b> |
| 131101      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж   | 129,284,281.00        |
| 131103      | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,000,000.00         |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө  | 14,690,900.00         |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                                | 7,556,397.00          |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мөст сумын Засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн “Орон нутгийн хөгжил дэвшилд манлайлагч байж мэдлэг чадварт суурилсан нутгийн захиргааны мэргэшсэн байгууллага байх” эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон дараах зорилтыг тавин ажилласан байна.Үүнд:

- ✓ Хууль тогтоомж, хөгжлийн бодлого, стратеги зорилт, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохин байгуулж хяналт тавих
- ✓ Баг байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, мэргэшил арга зүйн удирдлагаар хангах
- ✓ Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохин байгуулах
- ✓ Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохин байгуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тайлагнах, хяналт тавих
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг
- ✓ Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, цахим систем нэвтрүүлж, иргэдийн цаг хугацаа зардлыг хэмнэх
- ✓ Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ,
- ✓ Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 4 удаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 1 удаа, Төсвийн тухай хуульд 6 удаа, Шилэн дансны тухай хуульд 1 удаагийн өөрчлөлт орж Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдан мөрдөгдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 5 дугаар сарын 20-ний өдрийн 17-р тогтоолоор байгуулагдсан сумын өмч хамгаалах байнгын зөвлөл тус сумын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж төсвийн хөрөнгөөр болон хандив тусламжаар ирсэн хөрөнгөд хяналт тавин ИТХ-ийн хуралдаанаар тогтоол гаргуулан өмч хөрөнгийг бүртгэлд тусгуулж, актлах хөрөнгийг шийдвэрийн дагуу устгах ажлыг хариуцан ажиллаж жилийн ажлыг 88.7 хувьтай дүгнүүлсэн байна.

Мөст сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөст сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мөст сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,037.9 сая төгрөгөөр буюу 70.4 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

| Тайлангийн үзүүлэлтүүд                         | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /сая төгрөгөөр/ |             |
|--|----------------|-----------------|-----------------|-------------|
|  |                |                 | Өөрчлөлт        |             |
| Мөнгөн хөрөнгө                                 | 233.0          | 179.5           | 53.5            | 0.7         |
| Авлага   | 251.6          | 245.1           | 6,5             | 0.9         |
| Урьдчилгаа                                     | 177.5          | 182.5           | -5,0            | 102.0       |
| Бараа материал                                 | 328.6          | 40.3            | 288.3           | 12.4        |
| Үндсэн хөрөнгө                                 | 5890.0         | 1390.5          | 4,499.5         | 23.6        |
| <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>                      | <b>6880.7</b>  | <b>2037.9</b>   | <b>4,842.8</b>  | <b>29.6</b> |
| Богино хугацаат өр төлбөр                      | 86.0           | 14.8            | 71.2            | 17.2        |
| Цэвэр хөрөнгө, өмч                             | 6794.7         | 2023.1          | 4,771.6         | 29.7        |
| <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ<br/>ӨМЧИЙН ДҮН</b> | <b>6880.7</b>  | <b>2037.9</b>   | <b>4,842.8</b>  | <b>0.2</b>  |

Эх сурвалж: Мөст сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад, санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө цэвэр өмч хөрөнгийн данснууд байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 233.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 179.5 сая төгрөг болж 53.5 сая төгрөгөөр буюу 77 хувиар буурсан байна. Аймгаас сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг бууруулсантай холбоотой урьд оны давсан орлогыг сумын ИТХ-ын тогтоолоор орон нутгийн санхүүгийн дэмжлэгт хуваарилсантай холбоотой буурсан байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 245.1 сая төгрөг болж, өмнөх оноос 6.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр

| Үзүүлэлт                     | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|------------------------------|----------------|-----------------|------------------------|
| Байгууллагаас авах авлага    | 80.5           | 32.16           | (48.34)                |
| Хувь хүмүүсээс авах авлага   | 118.0          | 159.8           | 41.8                   |
| Аж ахуйн нэгжээс авах авлага | 53.1           | 53.1            | -                      |
| <b>Дүн</b>                   | <b>251.6</b>   | <b>245.1</b>    | <b>(6.5)</b>           |

Эх сурвалж: Мөст сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага 6.5 сая төгрөгөөр буурсан нь хоршоо хөгжүүлэх сангаас нэмж 49.0 сая төгрөгийн зээл гаргаж зээлийн авлагыг 41.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, Улсын төсвийн байгууллагуудын балансыг шилжүүлсэнтэй холбоотой өөрчлөгдсөн байна.

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 182.5 сая төгрөг болж, өмнөх оноос 5,0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт               | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|------------------------|----------------|-----------------|------------------------|
| Урьдчилж гарсан зардал | 88.0           | 93.0            | 5.0                    |
| Тусгай зориулалтын сан | 89.5           | 89.5            | -                      |
| <b>Дүн</b>             | <b>177.5</b>   | <b>182.5</b>    | <b>5.0</b>             |

Эх сурвалж: Мөст сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөст сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн дуусаагүй ажлуудыг тухайн ажлыг улсын комисс хүлээж аваагүй урьдчилж гарсан зардал дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 40.3 сая төгрөг болж 288.3 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 4. Бараа материал дансны үлдэгдэл*

| Тайлангийн үзүүлэлтүүд     | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /сая төгрөгөөр/<br>Өөрчлөлт |
|----------------------------|----------------|-----------------|-----------------------------|
| <b>Түүхий эд материал</b>  | <b>99.6</b>    | <b>0.00</b>     | <b>- 99.6</b>               |
| Эм боох материал           | 99.6           | 0.00            | -99.6                       |
| Бэлэн бүтээгдэхүүн         | 3.85           | 0.00            | -3.85                       |
| <b>Хангамжийн материал</b> | <b>224.92</b>  | <b>40.22</b>    | <b>178.7</b>                |
| Бичиг хэргийн материал     | 1.75           | 0.4             | -1.35                       |
| Аж ахуйн материал          | 16.4           | 8.86            | 7.54                        |
| сэлбэг хэрэгсэл            | 2.98           | 2.14            | -0.84                       |
| Түлш шатах тослох материал | 44.9           | 7.10            | -37.8                       |
| Барилгын засварын материал | 3.29           | 3.73            | 0.46                        |
| Хүнсний материал           | 21.8           | 0.00            | -21.8                       |
| Бусад хангамжийн материал  | 127.7          | 17.98           | -109.7                      |
| <b>Мал амьтад</b>          | <b>6.1</b>     | <b>0.0</b>      | <b>6.1</b>                  |
| <b>Нийт бараа материал</b> | <b>328.6</b>   | <b>40.3</b>     | <b>288.3</b>                |

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 74.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, аймгаас буцаан олгох нөхцөлтэйгөөр 10.0 сая төгрөгийн өвс тэжээлийн нөөц бүрдүүлж, 77.7 сая төгрөгийн материалыг зарцуулж, 293.1 сая төгрөгийн бараа материалыг улсын төсвийн байгууллагуудын балансаас балансаж шилжүүлсэнтэй холбоотой өөрчлөлт орсон байна.

### 3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 8153.7 сая төгрөг байсан бол оны эцэст 1390.5 сая төгрөг болж 6763.2 сая төгрөгөөр буурсан нь 6087.4 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж, 6.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хассан, 117.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой буурсан байна.

### 3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 86.0 сая, эцсийн үлдэгдэл 14.7 сая төгрөг болж 71.3 сая төгрөгөөр буурсан байна. Тайлан хугацаанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс буцаан олгох нөхцөлтэйгөөр 10.0 сая төгрөгийн санхүүжилт авч тэжээл бэлтгэсэн, балансаас балансад 66.7 сая төгрөгийн өглөг шилжүүлсэнтэй холбоотой байна.

### 3.4.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 6794.7 сая төгрөг байснаас оны эцэст 2023.1 сая төгрөг болж 4771.6 сая төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн баланс шилжсэнтэй холбоотой.

## 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1194.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1194.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Мөст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 04 өдрийн 5/07 тоот тогтоолоор 1153.3 сая төгрөгөөр анх баталж өмнө оны болон тайлант оны давсан орлоготой холбоотойгоор 2022 онд 1 удаа тодотгол хийн 2022 оны 06 дугаар сарын 20-ны 6/02 тоот тогтоолоор нийт 1194.2 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 6/02 тоот тогтоолоор 126.9 сая төгрөгөөр тодотгож баталжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1194.2 сая төгрөгийн төсөв баталснаас 1100.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 623.7 сая төгрөг татварын болон татварын бус орлогоос, 227.5 сая төгрөгийг ОХНС-аас санхүүжих, 1,1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 25.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагаанаас санхүүжүүлжээ.

Хүснэгт 5. Нийт орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл сая төгрөгөөр

| Санхүүжилтийн эх үүсвэр                      | Төлөвлөгөө    | Гүйцэтгэл     |
|--|---------------|---------------|
| <b>Татварын болон татварын бус орлого</b>    | <b>779.5</b>  | <b>739.2</b>  |
| Татварын орлого                              | 661.5         | 618.7         |
| Татварын бус орлого                          | 117.9         | 120.4         |
| <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>        | <b>1133.5</b> | <b>1074.5</b> |
| Орон нутгийн төсвөөс                         | 905.8         | 846.8         |
| Орон нутгийн хөгжлийн сан                    | 227.7         | 227.7         |
| <b>Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас</b> | <b>60.6</b>   | <b>26.2</b>   |
| Туслах үйл ажиллагааны орлогоос              | -             | 25.0          |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос              | 0.6           | 1.1           |
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих                | 60.0          | -             |
| <b>Засаг даргын захирамж</b>                 |               |               |
| <b>ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН</b>                 | <b>1194.2</b> | <b>1100.7</b> |

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс .... орон нутгийн татварын болон татварын бус орлого 623.7, ОХНС-ийн санхүүжилт 227.7, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1.1, туслах үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 26.2, урьд оны үлдэгдлээс 126.9 сая төгрөгийг зарцуулах эрх нээлгэж нийт 1100.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1043.1 сая төгрөгийг зарцуулж 21.8 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогод буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1043.1 сая төгрөг буюу 87.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 17.5 сая, Бараа үйлчилгээний бусад зардал 0.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 0,9 сая, байр ашиглахтай холбоотой зардал 3.1 сая, хангамж бараа материал зардалд 0.3 сая төгрөг, урсгал шилжүүлэг 27.3 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн зээл 49.0 сая төгрөг олгосон байна. нийт 57.6 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6 сая төгрөг батлагдаж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 1.1 сая, туслах үйл ажиллагааны орлогоос сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 19.7 сая, хүүгийн орлого ... сая, нийт 26.2 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Хүснэгт 6. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төгрөг/

|                 |          |       |
|-----------------|----------|-------|
| Орлогын ангилал | 2022 оны | Зөрүү |
|-----------------|----------|-------|

|   | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |          |
|---|------------|-----------|----------|
| Татварын нийт орлогын дүн   | 779.5      | 739.2     | 40.3     |
| Нийт орлого ба тусламжийн дүн   | 779.5      | 739.2     | 40.3     |
| Татварын орлого   | 661.5      | 618.7     | 42.8     |
| Орлогын албан татвар  | 211.99     | 214.79    | (2.8)    |
| Хувь хүний орлогын албан татвар   | 211.99     | 214.79    | (2.8)    |
| Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын | 138.4      | 161.6     | (23.1)   |
| Үйл ажиллагааны орлого  | 9.90       | 14.97     | (5.0)    |
| Шууд бус орлого   | 30.60      | 13.06     | 17.5     |
| Хөрөнгийн албан татвар  | 54.33      | 50.64     | 3.6      |
| Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар   | 1.50       | 2.29      | (0.7)    |
| Бууны албан татвар  | 2.83       | 3.72      | (0.8)    |
| Малын тоо толгойн албан татвар  | 50.00      | 44.62     | 5.3      |
| Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого   | 33.00      | 22.01     | 10.98    |
| Бусад татвар, төлбөр, хураамж   | 395.24     | 353.31    | 41.92    |
| Бусад нийтлэг төлбөр, хураамж   | 4.06       | 54.46     | ( 54.46) |
| Улсын тэмдэгтийн хураамж  | 2.00       | 51.20     | (49.2)   |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны  | 0.1        | 0.1       | -        |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж   | 1.0        | 2.2       | (1.2)    |
| Газрын төлбөр   | 1.68       | 2.19      | (0.5)    |
| Газрын төлбөр   | 4.31       | 2.90      | 1.4      |
| Дуудлага худалдаа   | -          | -         | -        |
| Байгалийн нөөц ашигласны төлбөр   | 389.49     | 296.65    | 92.8     |
| Ан амьтны нөөц ашигласны төлбөр   | 387.99     | 295.11    | 92.8     |
| Ус, рашааны нөөц ашигласны төлбөр   | 0.5        | 0.5       | (0.0)    |
| Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр  | 1.00       | 1.00      | -        |
| Татварын бус орлого   | 117.96     | 120.44    | (2.4)    |
| Нийтлэг татварын бус орлого   | 3.60       | 6.09      | (2.4)    |
| Хувьцааны ногдол ашиг   | -          | -         | -        |
| Торгуулийн орлого   | 3.0        | 4.96      | (1.9)    |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого   | 0.60       | 0.60      | -        |

Эх сурвалж: Мөст сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нээлтгэсэн тайлан

Нийт орлого 739,2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Татварын орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 23,1 сая төгрөг, үйл ажиллагааны орлого 5,0 сая төгрөг, хөрөнгө борлуулсны орлого 3,1 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн татвар 0,8 сая төгрөг, бууны албан татвар 0,8 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 49,2 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1,2 сая төгрөг, газрын төлбөр 0,5 сая төгрөг, торгуулийн орлого 1,9 сая төгрөгөөр тус тус орлого давж, хөрөнгийн орлого 10,9 сая сая төгрөг, шууд бус орлого 17,5 сая төгрөг, малд ногдуулах татвар 5,4 сая төгрөг, ан амьтан нөөц ашигласны төлбөр 92,9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 10.0 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 7.3 сая, Шим –Ус ОНӨААТҮГ-аас 6,0 сая төгрөг, төсвийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 1.1, статистикийн хэлтсээс 2.0 сая төгрөг, хог хаягдал 3.3 сая, сумын 90 жилийн ойн хандив 111.1 сая төгрөг, ИТХ-аас хүүхэд хамгааллын багт 0.4 сая, шүлхийн дархлаажуулалтын зардал 13,1 сая төгрөг аймгийн ЗДНХ-өөс 0.4 сая, ГХУСЗЗ-өөс 1.0 сая төгрөг нийт 5.8 сая төгрөгийг төвлөрүүлэн бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал дансанд тайлагнан үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мөст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүү нягтлан бодох бүртгэл, хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Бадрал, гэрээт аудитор М.Энхжаргал нар 2022 оны 03 дугаар сарын 20-ноос 03 дугаар сарын 25–ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн 1/04 албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,145.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 22.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдал тооцох хувийг 80 хувиар буюу 18.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ЗДТГ-нь байгууллагын төсвөөс 0.03 сая төгрөгийн ном худалдан зардал гаргасан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, ЗДТГ, ИТХ, Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлсэн бөгөөд төсөв өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийн мэдээллийг мэдээлээгүйг аудитын явцад залруулан цахим системд мэдээлүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### 4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгөгдсөн 0.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт барагдаж 129.0 сая төгрөгийн 1 албан шаардлага 57.4 сая төгрөгийн 6 зөвлөмж өгөгдсөнийг 76.8 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 7. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт        | Өмнөх оны илрүүлэлт |              | Биелэлт  |             |          | /мянган төгрөгөөр/<br>Зөрүү |             |
|-----------------|---------------------|--------------|----------|-------------|----------|-----------------------------|-------------|
|                 | Тоо                 | Дүн          | Тоо      | Дүн         | Тоо      | Дүн                         | Хувь        |
| Акт             | 1                   | 0.6          | 1        | 0.6         | -        | -                           | 100.0       |
| Албан шаардлага | 1                   | 129.0        | 1        | 39.5        | -        | -                           | 30.6        |
| Зөвлөмж         | 6                   | 57.4         | 6        | 57.4        | -        | -                           | 100.0       |
| <b>Нийт дүн</b> | <b>8</b>            | <b>187.0</b> | <b>7</b> | <b>97.5</b> | <b>-</b> | <b>-</b>                    | <b>76.8</b> |

##### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансад бүртгэлтэй 86.0 сая төгрөгийн малжуулах төслийн зээлийн авлагын хугацаа 2023 онд дуусаж байгаатай холбоотой дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 15.4 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 15.4 сая төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- ✓ **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Худгийн гадна тохижилт хийгдэж дуусаагүй байхад 5.0 сая төгрөгийг шууд зардалд бүртгэснийг авлага дансанд, бараа материал

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

зарлагдахдаа цалингийн зардал сонгож бүртгэсэн нь үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд зардал 10.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 241.6 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 101.3 сая төгрөгийн 2 зөвлөмж, 140.3 сая төгрөгийн 1 албан шаардлага өглөө.

### **5.1 Албан шаардлага**

- Сумын ЭМТ нийлүүлсэн гэрээт ажлын анхны гэрээний дагуу хэрэгжүүлээгүй 3 өөр орлогын баримт бүрдүүлсэн, гэрээний хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлээгүй

- ОНХС-гаас хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлээгүй, байгууллагын хөрөнгийн бүртгэлд бүртгэгдэж байсан 6.9 сая төгрөгийн өртөгтэй хуучин худгийн барилгад шинээр ухаалаг худаг суурилуулах гэрээт ажлыг 39.9 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр гэрээ хийж, төсвийн тооцоолол бодит бус

- Орон нутгийн хөгжлийн сангийн балансад бүртгэлтэй 89.5 сая төгрөгийн авлагыг бууруулах талаар тодорхой ажил хэрэгжүүлээгүй. Үүнээс малжуулах төслийн 86.0 төгрөгийн авлагыг эргэлтэд оруулаагүй, хашааны авлагын 3.5 сая төгрөгийг барагдуулаагүй, өмнөх оны шийдвэрийн хэрэгжилт хангагдаагүй зэрэг зөрчлүүд илэрлээ.

### **5.2 Зөвлөмж**

#### **5.2.1 ОНХС-ийн зарцуулалттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: ОНХС -аас шүлхийн ариутгалд ашиглахаар авсан 1.0 сая төгрөгийн ариутгалын савыг ЗДТГ-т бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна гэсэн хуулийн заалтын хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн орлогыг 2023 оны эхний хагас жилд багтаан орлогод бүртгэх

#### **5.2.1 Орлогын бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Сум байгуулагдсаны түүхт 80 жилийн ойн хандив бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг олон нийтэд түгээсэн ч баталгаажуулаагүй, хувь иргэний нэрээр данс нээж 100.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж Төрийн сангийн хяналтгүйгээр зарцуулсан байна. Аудитаар түүвэрлэн хянахад анхан шатны баримтуудын бүрдүүлэлт хангалтгүй байна.

Өгсөн зөвлөмж : Хууль тогтоомжийн заалтыг хэрэгжүүлж ойн хандив бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг олон нийтэд мэдээлэх, Хандив тусламжийн орлогыг төрийн сангийн дансаар дамжуулан зарцуулж, алдааг давтан гаргахгүй ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая.төгрөгөөр/

| Алдааны товч утга   | Нийт алдаа |             | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |             | Буруу тусган илэрхийлсэн |          | Үүнээс     |             |
|---|------------|-------------|-----------------------------------|-------------|--------------------------|----------|------------|-------------|
|   |            |             |                                   |             |                          |          | Залруулсан |             |
|   | Тоо        | Дүн         | Тоо                               | Дүн         | Тоо                      | Дүн      | Тоо        | Дүн         |
| Бараа материал зарлагдахдаа цалингийн зардал сонгож үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд зардлыг 10.4 сая төгрөгөөр буруу илэрхийлсэн | 1          | 10.4        | 1                                 | 10.4        |                          |          | 1          | 10.4        |
| Худгийн гадна тохижилт хийгдэж дуусаагүй байхад 5.0 сая төгрөгийн зардлыг шууд зардалд бүртгэснийг                                      | 1          | 5.0         | 1                                 | 5.0         |                          |          | 1          | 5.0         |
| <b>Дүн</b>  | <b>2</b>   | <b>15.4</b> | <b>2</b>                          | <b>15.4</b> | <b>-</b>                 | <b>-</b> | <b>2</b>   | <b>15.4</b> |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга  | Нийт зөрчил |              | Үүнээс   |              |                 |              |               |          |
|---|-------------|--------------|----------|--------------|-----------------|--------------|---------------|----------|
|   |             |              | Зөвлөмж  |              | Албан шаардлага |              | Төлбөрийн акт |          |
|   | Тоо         | Дүн          | Тоо      | Дүн          | Тоо             | Дүн          | Тоо           | Дүн      |
| Ой арга хэмжээний зарцуулалтын анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу, бараа материалын тайлан гаргаагүй, худалдан авсан үндсэн хөрөнгө орлогод аваагүй, | 1           | 100.3        | 1        | 100.3        |                 |              |               |          |
| ОНХС -аас шүлхийн ариутгалд ашиглахаар авсан 1.0 сая төгрөгийн ариутгалын сав бүртгээгүй  | 1           | 1.0          | 1        | 1.0          |                 |              |               |          |
| ОНХС-гаар хэрэгжүүлсэн ажлын хэрэгжилт хангалтгүй, төсвийг үр ашигтай хэмнэлттэй байх зарчмаар хэрэгжүүлээгүй   | 1           | 140.3        |          |              | 1               | 140.3        |               |          |
| <b>Дүн</b>  | <b>3</b>    | <b>241.6</b> | <b>2</b> | <b>101.3</b> | <b>1</b>        | <b>140.3</b> | <b>-</b>      | <b>-</b> |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИНСЭН:

АУДИТОР

 Ц.БАДРАЛ

АУДИТОР:

 М.ЭНХЖАРГАЛ



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 31/A2171111

Ховд

ХОА-2022/10/НА-СТА-ТТЗ

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мөст сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланд аудит хийхэд ОНХС-аас 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдсан сумын ЭМТ нийлүүлсэн гэрээт ажлыг анхны гэрээний дагуу хэрэгжүүлээгүй 3 өөр орлогын баримт бүрдүүлсэн, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлээгүй, байгууллагын хөрөнгийн бүртгэлд бүртгэгдэж байсан 6.9 сая төгрөгийн өртөгтэй хуучин худгийн барилгад шинээр ухаалаг худаг суурилуулах гэрээт ажлыг 39.9 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр гэрээ хийсэн тооцоололд магадлалгүй хэт өндөр төсвөөр гүйцэтгэсэн, өмнөх оны орон нутгийн хөгжлийн сангийн балансад бүртгэлтэй 89.5 сая төгрөгийн авлагыг бууруулах талаар тодорхой ажил хэрэгжүүлээгүй малжуулах төслийн 86.0 төгрөгийн авлагыг эргэлтэд оруулаагүй, хашааны авлагын 3.5 сая төгрөгийг барагдуулаагүй зөрчлүүд илэрлээ.

Энэ нь ОНХС-ийн үйл ажиллагааны журам 3.1.3-д ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх, 3.3.7.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох хууль, аргачлал, журамд нийцүүлэн хийх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих; Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах" 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сумын эрүүл мэндийн төвд нийлүүлсэн гэрээт ажилд дотоод хяналт хэрэгжүүлэн гэрээнд заасан бараа материалыг нийлүүлэн авч ажиллах
2. Малжуулах төслийн авлагын гэрээний хэрэгжилтийг тооцон эргэлтэд оруулж гэрээг шинэчлэн ажиллах
3. Хашааны 3.5 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар санаачлага гарган ажиллах
4. ОНХС-аас хэрэгжүүлэх, ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох хууль, аргачлал, журамд нийцүүлэн хийх, худалдан авах ажиллагааг үр дүнтэй хэмнэлттэй төсөл арга хэмжээнд зарцуулах

5. Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> хариуг албан бичгээр ирүүлэхийг ирүүлэхийг Засаг дарга С.Баасандорж, санхүүгийн албан дарга Б.Нямаа, орон нутгийн хөгжлийн сан хариуцсан нягтлан бодогч Б.Мягмарсүрэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

АУДИТОР

Ц.БАДРАЛ

---

<sup>1</sup> Монгол улс, Ховд аймаг, Цамбагарав баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас: 70433061, 70432545